



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А109

Улаанбаатар хот

Цусны донор, донор зохион байгуулагчид
олгох урамшууллыг шинэчлэн батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Донорын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Үндэсний аудитын газрын зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ бэлэглэсэн цусны донорт олгох хүнсний багцыг 1 дүгээр, донор зохион байгуулагчид олгох урамшууллыг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Цус, сийвэн цуглуулах төлөвлөгөөг харгалзан, батлагдсан төсөвт багтаан донорт олгох хүнсний багцын үнийг шинэчлэн тогтоох саналыг төсвийн төсөлд тусган, танилцуулж байхыг Санхүү, бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Б.Өнөрзул/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч /Ч.Тунгалаг/, Санхүү, бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Б.Өнөрзул/ нарт, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, маркетингийн албаны дарга /Ч.Батболд/-д тус тус даасгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Төвийн Ерөнхий захирлын 2019 оны А/17 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


5. Тушаалыг 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2021 оны 03 дугаар сарын 31 ний өдрийн
110 дугаар тушаалын 2 дугаар хавсралт




Донор зохион байгуулагчид олгох урамшууллын хэмжээ

№	Элсүүлсэн донорын тоо	Олгох урамшууллын дүн
1.	60-79 хүртэл донор элсүүлсэн бол	15 000 төгрөг
2.	80-99 хүртэл донор элсүүлэн бол	20 000 төгрөг
3.	100-ээс донор элсүүлсэн бол	25 000 төгрөг

Тайлбар: “Элсүүлсэн донорын тоо”-г тухайн өдөрт, тухайн зохион байгуулагчийн зохион байгуулсан арга хэмжээний хүрээнд хамрагдаж цусаа бэлэглэсэн донорын тоогоор тооцож урамшуулал олгоно.

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2021 оны 03 дугаар сарын 31 ний өдрийн
А/03 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



Цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ бэлэглэсэн
цусны донорт олгох хүнсний багцын үнэ

№	Цус өгөлтийн төрөл	Хүнсний багц /үнэ төгрөгөөр/	Тайлбар
1.	Шинэ донор	2800	Сонголтоор
2.	Байнгын, сийвэнгийн болон сөрөг донор	5420	Сонголтоор
5.	Эсийн донор	8220	Сонголтоор
6.	Яуулын цус цуглуулалт	1850	-